



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/37

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Монголросцветмет" ХХК-ийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс аймгийн Засаг даргад холбогдуулан Хэнтий аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.1.4, 25.1.5, 25.1.6, 25.1.7, 25.1.8 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Г.Мөнх-Эрдэнэ, Татварын хэлтсийн хуулийн зөвлөх Б.Наранчимэг нарт олгож өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Засаг даргыг төлөөлж оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч /Г.Мөнх-Эрдэнэ/, Татварын хэлтсийн хуулийн зөвлөх /Б.Наранчимэг/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 250